



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН ШИЙДВЭР ДҮГНЭЛТ ӨГӨХ ТУХАЙ

2006 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Дархан

Дугаар 62

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймагт 2005-2006 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын шинэ стандарт сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар авч явуулсан арга хэмжээ, хийсэн ажлын талаарх тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж үзсүгэй.

2. Энэхүү ажлын дэлгэрэнгүй тайланг шинэ хичээлийн жилийн багш нарын бага хурлаар хэлэлцүүлэн цаашид улам эрчимжүүлж ажиллахыг аймгийн Боловсрол, соёлын газар /Д.Амгалан/-т даалгасугай.

ДАРГА Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ